

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2023 оны 12 дугаар сарын 13-ны өдөр, Лхагва гараг

| | |
|--|------------|
| <i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i> | <i>0</i> |
| <i>Хуралдааны товч тэмдэглэл:</i> | <i>1-2</i> |
| <i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i> | <i>3-4</i> |
| <hr/> | |
| <i>1. Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.11.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i> | <i>3-3</i> |
| <i>2. Мал аж ахуйн өвөлжилтийн өнөөгийн байдал, авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаарх Засгийн газрын мэдээллийг Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар сонссонтой холбогдуулан зохион байгуулж байгаа ажил, түүний явц байдлын талаар Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга С.Амарсайханы мэдээллийг сонсох</i> | <i>3-4</i> |

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы
Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны
12 дүгээр сарын 13-ны өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын айнгын хорооны дарга Ж.Батжаргал ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 33 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

*Томилолттой: Т.Аубакир, Ц.Идэрбат, Г.Мөнхцэцэг, Г.Тэмүүлэн, О.Цогтгэрэл;
Чөлөөтэй: Ц.Анандбазар, Х.Болорчулуун, Б.Саранчимэг.*

Нэг. Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.11.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, мөн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Есөн-Эрдэнэ, Хуулийн хэлтсийн дарга Э.Цолмонжаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Алтанцэцэг, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Б.Баярсайхан нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33 дугаар зүйлд заасны дагуу хууль санаачлагч хуралдаанд оролцоогүй тул Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг хойшлуулав./15:36/

Хоёр. Мал аж ахуйн өвөлжилтийн өнөөгийн байдал, авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаарх Засгийн газрын мэдээллийг Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар сонссонтой холбогдуулан зохион байгуулж байгаа ажил, түүний явц байдлын талаар Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга С.Амарсайханы мэдээллийг сонсох

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Онцгой байдлын ерөнхий газрын дэд дарга Б.Ууганбаяр, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, мөн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Есөн-Эрдэнэ, Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Г.Наранчулуун, Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Довчинсүрэн, Хуулийн хэлтсийн дарга Э.Цолмонжаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Б.Баярсайхан нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33 дугаар зүйлд заасны дагуу Засгийн газрын гишүүд хуралдаанд оролцоогүй тул Мал аж ахуйн өвөлжилтийн өнөөгийн байдал, авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаарх Засгийн газрын мэдээллийг хойшлуулав./15:44/

Хуралдаан 11 минут үргэлжилж, 19 гишүүнээс 11 гишүүн ирж, 57.9 хувийн ирцтэйгээр 15 цаг 44 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС,
ХӨДӨӨ АЖ АХУЙН
БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

Ж.БАТЖАРГАЛ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 12 дугаар сарын 13-ны өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”
танхим, 15 цаг 33 минут

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ж.Батжаргал: Байнгын хорооны гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Улсын Их Хурлын гишүүн Батжаргал, Бат-Эрдэнэ, Бейсен, Ганболд, Ганибал, Дамдинням, Наранбаатар, Туваан, Цэрэнпунцаг, Энхтүвшин гишүүд хүрэлцэн ирж, Байнгын хорооны хуралдааны ирц 52.6 хувьтай байгаа тул Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2023 оны 12 дугаар сарын 13-ны хуралдааныг нээе.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. 2 асуудал байна.

1. Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд Засгийн газар 2023.11.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх.

2. Мал аж ахуйн өвөлжилтийн өнөөгийн байдал, авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаарх Засгийн газрын мэдээллийг Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар сонссонтой холбогдуулан зохион байгуулж байгаа ажил, түүний явц байдлын талаар Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга С.Амарсайханы мэдээллийг сонсох гэсэн ийм 2 асуудал байна.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулж саналтай гишүүд байна уу. Саналтай гишүүн байхгүй байна. Тийм учраас хэлэлцэх асуудлын төлөвлөгөө батлагдлаа.

Хэлэлцэх асуудалдаа орёе. Ажлын хэсгийн гишүүдийг оруулаарай.

Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэхийг хэлэлцье.

Хууль санаачлагчийн танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун танилцуулна. Болорчулуун сайд. Сайдыг оруулж ирээрэй. Ойрхон байна уу. Болорчулуун сайд байхгүй байгаа бол Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33.2-т зааснаар Засгийн газраас санаачилсан хуулийн төслийн танилцуулгыг Ерөнхий сайд эсхүл тухайн асуудлыг эрхэлсэн Засгийн газрын гишүүн, тухайн Засгийн газрын гишүүн түр эзгүй байгаа бол түүнийг орлож байгаа Засгийн газрын гишүүн хийнэ гэсэн ийм дэгийн хуультай. Тийм учраа эрхэлсэн сайд нь байхгүй байгаа тул энэ асуудлыг хойшлууллаа.

15.36 цаг.

Хэлэлцэх асуудлын төлөвлөгөөний дагуу хоёр дахь асуудлаа хэлэлцэж эхэлье.

Мал аж ахуйн өвөлжилтийн өнөөгийн байдал, авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаарх Засгийн газрын мэдээллийг Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар сонссонтой холбогдуулан зохион байгуулж байгаа ажил, түүний явц байдлын талаар мэдээлэл.

Мэдээллийг Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн

үйлдвэрийн сайд Болорчулуун танилцуулна.

Ажлын хэсгийг оруулаарай.

Мал аж ахуйн өвөлжилтийн өнөөгийн байдал, авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаарх Засгийн газрын мэдээллийг Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар сонссонтой холбогдуулан зохион байгуулж байгаа ажил, түүний явц байдлын талаарх мэдээллийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга Амарсайханы мэдээлэл сонсох байсан. Амарсайхан дарга хөдөө, орон нутагт томилолттой ажиллаж байгаа.

Засгийн газрын гишүүн, Онцгой комиссын гишүүн мэдээллийг орлож хийхээр байсан. Сайд хүрэлцэн ирээгүй тул энэ асуудлыг хойшлууллаа.

15.44 цаг.

Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдааны үйл ажиллагааг хааж байна.

Дууны бичлэгээс буулгасан:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ